

## Тавантолгойн ордыг ашиглах тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах үзэл баримтлалын талаар Засгийн газраас танилцуулсан баримт бичгийн төслүүдийг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

1. Тавантолгойн ордыг ашиглах болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил, бусад холбогдох төслийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын үндэсний болон төр, иргэд, аж ахуйн нэгжийн эрх ашгийг нэн тэргүүнд эрхэмлэх,

2. Тавантолгойн ордыг ашиглах гэрээг Монгол Улсын хуульд нийцүүлэн хийж, ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 100 хувь төрийн өмчит компанийн мэдэлд байлгаж, цаашид ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий төрийн өмчит компанийн хувьцааг Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх арга хэмжээг холбогдох хуулийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэх,

3. Нүүрсний нөөц, олборлолтын нөхцөлийг харгалзан Тавантолгойн ордын тодорхой хэсгийг хамтран ашиглах хөрөнгө оруулагчдын урьдчилан сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод хэрэгжүүлж, яриа хэлэлцээ явуулахыг Засгийн газар (С.Батболд)-т үүрэг болгосугай. Үүнд:

а/ Урьдчилсан сонгон шалгаруулалт, яриа хэлэлцээг улс орны хөгжлийн гадаад таатай орчинг бүрдүүлэх, улс төр, эдийн засгийн тэнцвэртэй харилцааг бэхжүүлэхэд чиглүүлж, нэвтрэх, дамжин өнгөрөх тээвэр, зах зээлд гарах гарцыг нэмэгдүүлэх, татвар, тарифын хөнгөлөлт авах зэрэг тодорхой улс орнуудад угтуулан тавих нөхцөлийг боловсруулж, Засгийн газрын түвшинд яриа хэлэлцээ хийх;

б/ Орд ашиглах хувилбарын хүрээнд Тавантолгойн нүүрсийг урт хугацаанд байнга, тогтвортой худалдан авах буюу борлуулах, урьдчилгаа төлбөрийн хэмжээ, нөхцөлийн асуудлыг нарийвчлан тохирох, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх (кокс, химийн болон ган хайлуулах үйлдвэрлэл, цахилгаан станц барьж байгуулах гэх мэт) нөхцөлийг бүрдүүлэх;

в/ Хөрөнгө оруулагчдын туршлага, санхүүгийн чадвар, байгаль орчинд ээлтэй технологи, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, стандарт, бүс нутгийн дэд бүтэц,

усны хайгуул, ашиглалт, бүтээгдэхүүний үнэ, зах зээл, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулах санал зэрэг үзүүлэлтийг шалгуур болгох;

г/ Хот төлөвлөлт, ордыг түшиглэсэн үйлдвэр, барилга байгууламж, дэд бүтэц, зам, тоног төхөөрөмжийг барьж байгуулах, ашиглахад олон улсын жишиг стандарт (Европын Холбооны)-ыг баримтлан, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлоготой уялдуулж, Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах, Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд авч хэрэглэх нөхцөл болзлыг хэрэгжүүлэх;

д/ Тавантолгойн ордыг ашиглах сонгон шалгаруулалтад гадаадын аж ахуйн нэгжийг оролцуулах бол нэг компани буюу консорциум гэсэн зарчим баримталж, яриа хэлэлцээний дүнг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд урьдчилан танилцуулах;

4. Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл, нүүрсний олборлолтын гэрээний төсөл, урьдчилсан сонгон шалгаруулалтын баримт бичгийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг дэмжиж, энэхүү зөвлөмжид заасан зарчмын саналуудыг тусган Улсын Их Хуралд танилцуулах нь зүйтэй гэж үзэв.